



Зүүн гар талаас: Mining Shared Value төслийн зөвлөх John Kielty, байгууллагын тэргүүн Jeff Geipel

ОРОН НУТГИЙН ХУДАЛДАН АВАЛТ ХӨГЖИХ НӨХЦӨЛ БҮРДСЭН

Орон нутаг дахь худалдан авалтын тайлан гэх ойлголт нь Монголд шинэлэг зүйл бөгөөд Канадад төвтэй Хил хязгааргүй инженерүүд байгууллагын дэмжлэгтэйгээр үйл ажиллагаа явуулдаг Mining Shared Value байгууллага уг чиглэлээр манай улсад төсөл хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа юм. Тус байгууллагын тэргүүн Jeff Geipel, төслийн зөвлөх John Kielty нартай төслийн хүрээнд хэрэгжих ажил хэрэг болоод Монголын уул уурхайн салбар төслийн үр дүнгээс ямар өгөөж хүртэх талаар ярилцлаа.

Монгол улсад хэрэгжүүлэхээр ажиллаж буй орон нутгийн худалдан авалтын тайлангийн талаар тодруулна уу? Тэр тусмаа Mining Shared Value буюу Уул уурхайн хамтын үнэ цэн гэж юу вэ?

John Kielty: Канадын Хил хязгааргүй инженерүүд байгууллагын дэмжлэгтэйгээр үйл ажиллагаа явуулдаг Mining Shared Value (MSV) нь тухайн орны уул уурхайн салбараас хүртэх нийгэм, эдийн засгийн өгөөжийг илүү их байлгахын тулд уг салбар дахь орон нутгийн худалдан авалтыг сайжруулах чиглэлээр ажилладаг. 2012 оноос хойш MSV нь Канадын уугуул иргэдийн эрхэлдэг бизнес үйл ажиллагаанаас хийж буй нийлүүлэлтийг судлах, Африкийн Сахарын өмнөд бүсэд орон нутгийн эх үүсвэрийг ашиглах тухай дүрэм журам нь салбарын компанийн зарчимд хэрхэн нөлөөлж буй тухайд дүн шинжилгээ хийх зэрэг төслүүдийг хэрэгжүүлснээр орон нутгийн худалдан авалтын өгөөжийг дээшлүүлэх чиглэлд нааштай олон үр дүнд хүрсэн. Мөн MSV нь Дэлхийн банкны Уул уурхайн салбарын орон нутгийн бараа бүтээгдэхүүний хөгжлийг дэмжих туршилтын төслийн үндсэн гишүүнээр ажиллаж буй юм.

Канад болон дэлхийн уул уурхайн томоохон компаниуд орон нутгийн худалдан авалтаа хэрхэн нээлттэйгээр тайлагнадаг талаар MSV жил бүр тайлан мэдээлэл бэлтгэн гаргадаг юм. Тус компани уул уурхайн компаниудын

орон нутгийн худалдан авалтыг хэмжих, тайлагнахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран төсөл хэрэгжүүлж байна.

Одоогийн түгээмэл хэрэглэж байгаа тайлагналын ерөнхий арга аргачлал учир дутагдалтай учраас уул уурхайн орон нутгийн худалдан авалтын тайлагналын систем бий болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа юм. Дэлхийн тайлагналын санаачилга (GRI) гэх мэт байгууллага нь орон нутгийн худалдан авалтыг тайлагнахад дэмжлэг үзүүлдэг ч шаарддаг мэдээллийн хүрээ нь өргөн дэлгэр биш, уул уурхайн компаниуд болон тухайн улс орнуудад орон нутгийн худалдан авалтыг илүү сайн зохион байгуулахад нь дэмжлэг болохуйц мэдээлэл дутмаг байна. Бидний боловсруулж буй тайлангийн шинэ систем нь компаниудад тайлангийн дарамт үүсгэхгүйн тулд GRI шиг одоо байгаа стандартууд дээр ажиллах бололцоог бүрдүүлснээрээ чухал ач холбогдолтой.

Та Монголд саяхан хүрэлцэн ирсэн. Төслийн ажил хэр ахицтай байна вэ? Тайлагналын стандартыг хэрхэн хөгжүүлж байна вэ?

Jeff Geipel: Төсөл амжилттай урагшилж байна. Бид олон уулзалт, зөвлөгөөн хийж байж боловсруулсан тайлангийн стандартын төслөө Монгол, Албани, Мали зэрэг уул уурхайн үйл ажиллагаа явагдаж буй, бусдаасаа тэс

өөр орчинд туршилтаар хэрэгжүүлж байна.

Эдгээр туршилтын төсөл хэрэгжиж буй орнуудад бид уул уурхайн компаниуд, орон нутгийн, улсын засаг захиргаа, иргэний нийгмийн байгууллага, худалдааны танхим, уул уурхайн холбоод болон бусад оролцогч талтай тус бүрт нь уулзаж ярилцаж байна.

Орон нутгийн худалдан авалтын тайлангийн стандартыг бий болгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор хийсэн ганцаарчилсан болон бүлгийн уулзалт, ярилцлагууд, түүнээс гарсан санал санаачилгууд нь компаниудыг тайлагналын практик үйл ажиллагаанд татан оруулах, оролцогч талуудад тухайн уурхайн орон нутгийн худалдан авалтыг ойлгуулахад чухал ач холбогдолтой.

Эцсийн дүндээ, оролцогч талуудын дунд үр дүнтэй, өргөн хүрээний мэдээлэл солилцох уулзалтууд өрнөх боломжийг бүрдүүлж, тэдэнд боломжийн итгэл найдвар төрүүлэхэд дөхөм болох юм.

Мөн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС) зэрэг стандартчилгдсан тайлантай адилаар тухайн улс орон, уул уурхайн үйл ажиллагааны хооронд харьцуулалт хийж үзэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилготой адил юм.

Тайлангийн стандартыг хэрэгжүүлснээр ямар үр дүнд хүрнэ гэж та бүхэн харж байна вэ?

John Kielty: Орон нутгийн худалдан авалтын тайлангийн стандартыг энэ жилийн сүүлээр хийж дуусгана. Тэр үед энэ ажлыг орон нутаг дахь худалдан авалтаа тайлагнах гэж буй уул уурхайн ямар ч компани үйл ажиллагаандаа авч хэрэглэх боломжтой болох юм.

Уул уурхайн компаниудын тухайд өөрсдийн худалдан авалтын талаар илүү их мэдээлэлтэй болсноор орон нутаг, бүс нутаг, үндэсний хэмжээний аж ахуйн нэгжүүдээс чанартай бараа, үйлчилгээ авалтаа нэмэгдүүлэх, улмаар түүгээр дамжуулан зардлаа хэмнэх боломж бүрдүүлж чадна. Түүнчлэн энэ нь компаниудад орон нутгийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, үйл ажиллагаагаа цаашид явуулах нийгмийн лицензийг хадгалахад дөхөм үзүүлнэ.

Дэлхийн аль ч улсын уул уурхайн компаниуд уг стандартыг сайн дураараа авч хэрэгжүүлж болох бөгөөд тухайн компанийн Засгийн газартаа тайлагнадаг шаардлага эсвэл уул уурхайн холбоодын гишүүнчлэлийн нэг нөхцөл байж болно.

Засгийн газар, худалдааны танхим, үйл ажиллагаа явуулж буй болон ирээдүйн боломжит ханган нийлүүлэгчид, олон нийтийн байгууллагууд зэрэг гадаад оролцогч талуудын хувьд уул уурхайн компаниудын худалдан авалтын талаар мэдээлэлтэй болсноор эдийн засгийн үр ашиг хуваарилалтыг нэмэгдүүлэх, хяналт тавих чиглэлээр үр дүнтэй хэлэлцүүлэг хийх, ханган нийлүүлэгчдийн хөрөнгө оруулалтын стратегийн чиглэлийг тодорхойлох, оролцогч талуудын уул уурхайн компаниудтай хийх хамтын ажиллагааг илүү их зохион байгуулалттай болгох суурь бий болох юм.

Тайлангийн стандартыг Монголд хэдийгээр хэрэгжүүлэх вэ? Монгол улс энэ стандартыг хэрхэн ашиг тустайгаар хэрэглэх боломжтой вэ?

Jeff Geipel: Тайлангийн стандарт нь 2016 оны сүүлээр бэлэн болох бөгөөд тэр үед уул уурхайн компаниуд тайланг хүлээж аван тайлагналдаа ашиглаж болно. Монголын уул уурхайн ямар ч компани уг стандартыг хэрэглэх боломжтойгоос гадна тогтмол тайлагнадаг үйл

ажиллагааны нэг хэсэг болгон энэхүү орон нутаг дахь худалдан авалтын тайлагналыг оруулж болно. Тухайлбал жил бүрийн уурхайн болон байгаль орчны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн гэрээний үүргийн нэмэлтээр оруулж болно. Эдгээр тайлагналын механизмууд нь орон нутгийн засаг захиргаа болон улсын Засгийн газарт орон нутгийн болон улсын хэмжээний эдийн засгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтөд дэмжлэг үзүүлэхүйц мэдээлэл цуглуулах боломжийг олгодог.

Монголын орон нутгийн худалдан авалтад ямар хүндрэлтэй тал болон боломж байна вэ?

John Kielty: Монгол бол цөөн хүн ам, том газар нутагтай улс. Тиймээс уул уурхайн салбарын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд өргөн хүрээний харилцаа холбоо, зохицуулалт шаардагддаг. Хятад болон бусад нийлүүлэгчийг бодвол харьцангуй жижиг зах зээлийн хувьд тухайн улс үнэхээр өрсөлдөхүйц хэмжээнд нийлүүлж чадах бараа үйлчилгээг онилох нь хамгийн чухал юм.

Аймаг, сумын төвүүдэд маш олон бараа, үйлчилгээ аль хэдийн хөгжиж бий болсон ч уул уурхайн компаниудад юу хэрэгтэй талаар мэдээлэл төдий л хангалттай биш байна.

Уул уурхайн компаниуд орон нутагт үйл ажиллагаагаа явуулдаг ч Улаанбаатар хотод төвтэй байх хандлагатай учраас аймаг, сумдын засаг захиргааны хувьд компаниудтай тогтмол харилцаа холбоотой байх нөхцөл алга байна.

Тухайн бараа, үйлчилгээ нь Монголын орон нутагт тэр бүр байхгүй үед уул уурхайн компаниуд урт хугацааны зардлаа бууруулах, шинэ, өсөн нэмэгдэж буй орон нутгийн бизнест хөрөнгө оруулалт хийх замаар орон нутагтай эерэг харилцаа бий болгох боломжийг хардаггүй байж болох юм. Уурхай дахь хэрэгцээ болон орон нутгийн бизнест ямар зүйлсээр туслах боломжтой талаар илүү их мэдээлэл солилцоноор тухайн уурхайн ойролцоох нийлүүлэлтийн сүлжээг шинэчлэх боломжийг олж тогтоох тухайд хамтын ажиллагааг сайжруулах юм.

Та бусад улсын туршлагатай харьцуулж үзэхэд Монгол дахь орон нутгийн худалдан авалтын нөхцөл байдал ямар түвшинд байна вэ? Үүнийг хэрхэн сайжруулж болох вэ?

Jeff Geipel: Уул уурхайн эдийн засгийн үр ашиг одоогоор Монголд боломжит дээд хэмжээнд очоогүй байж болох ч компаниудын үйл ажиллагаа явуулж буй орон нутаг болон улс орон даяарх худалдан авалтыг нэмэгдүүлэх тал дээр танай улс маш боломжтой нөхцөлд байна.

Компаниудтай орон нутаг болон улсын хэмжээнд зарцуулах хөрөнгийг нэмэгдүүлэх тал дээр ажиллах оролцогч талуудад шаардлагатай бүх нөхцөл бүрдчихсэн байна. Аймаг, сумын засаг захиргаа нь уул уурхайн компаниудтай хамтран ажиллах сонирхолтой байдаг бөгөөд орон нутгийг хөгжүүлэх гэрээг нутгийн бизнесийг дэмжих хөшүүрэг болгож ашиглах сонирхолтой байна. Бизнесийн зөвлөлүүд болон худалдааны танхимууд нь ажиллаж байгаа газартаа гишүүдийнхээ бизнесийг уул уурхайн салбарт сурталчилж дэмжихийг хүсдэг. Илүү их мэдээлэлтэй болсноор оролцогч бүх тал уул уурхайд юу хэрэгтэй талаар нэг ойлголттойгоор ярилцаж чадна. Энэ нь Монгол Улсын Засгийн газар болон бизнесийн байгууллагууд нь тэдгээр хэрэгцээ шаардлагыг хэрхэн зорилтоо болгох талаарх хэлэлцүүлэгт дэм болно.